



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙД Д.ГАНБАТ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ

АСУУЛГА

210646 Улаанбаатар хот, Төрийн ордон
Сүхбаатарын талбай 6, Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2017.05.11 № 08

Асуулга тавих тухай

Манай улсын хувьд нүүдэлчдийн уламжлалт ёс заншил, түүх соёлын давтагдашгүй өв, унаган төрхөө хадгалж үлдсэн үзэсгэлэнт газар нутгийнхаа давуу тал дээрээ тулгуурласан аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг түргэсгэх, тогтвортой орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх боломжтой билээ. Гэвч аялал жуулчлалыг дэмжсэн дэд бүтэц сул, авто замын чанар, хөгжил муу байгаа зэрэг нь аялал жуулчлалын хөгжилд сөргөөр нөлөөлж, тулгамдсан асуудлын нэг болсоор байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13 дахь заалтыг үндэслэн дараах асуулгыг танд тавьж байна. Үүнд:

1. Аялал жуулчлалыг хөгжүүлэх төрийн бодлоготой уялдуулан агаарын болон авто замыг дунд хугацаанд хөгжүүлэх ямар ямар ажлуудыг хийхээр төлөвлөж байна. Тухайлбал Хөвсгөл нуурын сав газрыг тойрсон авто зам болон тухайн бус нутгийг Тэрхийн цагаан нуурын аялал жуулчлалын бүстэй холбосон авто замын асуудлуудын талаар

2. Манай олон улсын болон дотоодын нислэгийн захиалгыг төлөвлөхөд хүндрэлтэй, найдваргүй, цуцалдаг, үнэ нь хэт өндөр, жуулчдын ихээхэн ачааллыг даадаггүй бага хэмжээгээр л явуулах боломжтой гэх мэт шүүмжлэлийг гадаадын жуулчны компаниуд тавьдаг. Энэ асуудлыг шийдвэрлэх талаар ямар арга хэмжээнүүдийг авч байна.


3. Хатуу хучилттай 1 км авто замын стандарт, төсөвт өртөг өнөөдрийн байдлаар бүрэн тодорхойлогдсон эсэх, хэрхэн тодорхойлж шийдвэрлэж байгаа талаар. Тухайлбал Улсын төсвийн хөрөнгө, концессийн гэрээ, гадны зээл тусламжаар хэрэгжиж байгаа авто замын төсөвт өртөг өөр өөр байгааг хэрхэн

зохицуулах, энэ талаарх судалгааг гаргаж асуулгын хариуг хуульд заасан хугацаанд УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна уу.

Хувийг: Засгийн газрын хэрэг эрхлэх газарт.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Ц.ДАВААСҮРЭН